



МОНГОЛ УЛСАД

Тогтвортой хөгжлийн зорилгуудтай
уялдсан төсвийн төлөвлөлтөөр
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

(2020-2024)

ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД:



»»» Товч танилцуулга

ТӨСЛИЙН НЭР	МОНГОЛ УЛСАД ТХЗ-УУДАЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ
ХУГАЦАА	2020 оны 10 дугаар сар – 2024 оны 3 дугаар сар Нийт 42 сар
ТӨСӨВ	7.4 сая евро
САНХҮҮЖҮҮЛЭГЧ ТАЛ	Европын холбоо
ТӨСЛИЙН ЗОРИЛГО	- Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих - Хөдөлмөр эрхлэлтийн салбарт төрийн үйлчилгээг үр дүнтэй, хариуцлагатай, шуурхай хүргэхэд туслалцаа үзүүлэх - Төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн институтын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
ТӨСЛИЙН АШИГ ТУС ХҮРТЭГЧИД	- Ажил хайгч, ажилгүй эсвэл бүрэн бус хөдөлмөр эрхлэгч, түүний дотор алслагдсан нутгийн залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулах хүсэлтэй ажилчид - Ажил олгогчид - Татвар төлөгчид, Монгол Улсын иргэд
ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУД	- Сангийн яам - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам - Үндэсний аудитын газар - Мэргэжлийн хяналтын ерөнхий газар - Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо - Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо - Бусад
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА	- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) - НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) - Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)



»»» ҮР ДҮН


- Төсөв боловсруулах үйл явцыг сайжруулна.
- Төсвийн хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.
- Хөдөлмөр эрхлэх чадвар, боломжийг нэмэгдүүлнэ
- Хөдөлмөрийн харилцааны хууль эрх зүйн орчинг сайжруулна.



»» ҮР НӨЛӨӨ

Төсөв, санхүүгийн удирдлага, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжсэн байна.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД



БҮРЭЛДЭХҮҮН 1: БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ

1.1. ТӨСВИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ (ДУНД ХУГАЦААНЫ ЗАРЛАГЫН ХҮРЭЭ)

- Дунд хугацааны зарлагын хүрээ (ДХЗХ) буюу үр дүнд суурилсан төсөвлөлтийн тодорхой элементүүдийг нэвтрүүлэх шинэчлэлийн төлөвлөгөө боловсруулна.
- Үр дүнгийн мэдээлэлд үндэслэж ДХЗХ-г бэхжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

1.2. ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

- Төсвийн багц хөтөлбөрүүд үндэсний бодлого, стратеги төлөвлөгөө, үр дүнтэй уялдсан байна.
- Үр дүнд суурилсан төсвийн хяналт шинжилгээ, тайлагналын системийг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
- ТХЗ-ын иргэдийн төсвийг бэлтгэх буюу төлөвлөсөн үр дүнг төсвийн гүйцэтгэлтэй хамт салбар, яамдаар, энгийн ойлгомжтой хэлбэрээр гарган, ашиглахад хялбар болгоно.

1.3. НОТОЛГООНД СУУРИЛСАН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ

- Төсвийн шийдвэрийг мэдээлэл, нотолгоонд үндэслэн гаргадаг байхын тулд салбарын төсвийн зарлага, институтын бүтцэд үнэлгээ хийж үр дүнг тодорхойлон зөвлөмж гаргана.
- Салбарын хөтөлбөрийн эрэмбэлэлт буюу салбар хооронд, салбар дотроо баримтлах тэргүүлэх чиглэл, төсөл сонгон шалгаруулах үйл явцыг сайжруулна.
- Бодлого хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог сайжруулах буюу холбогдох байгууллагуудтай (ХНХЯ, ХХААХҮЯ-наас эхлэн) хамтран, салбарын хөтөлбөрийн зардлын тооцоог хийхэд дэмжлэг үзүүлнэ.

1.4. ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСӨВ, ТХЗ-ЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР САНГИЙН ЯАМ, САЛБАРЫН ЯАМДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛНЭ.

- Стратегийн Зөвлөх хороо байгуулан, Стратегийн зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.
- Бүсийн сургалт, танилцах аялал зохион байгуулна.
- Ажлын байранд чадавх бэхжүүлэх сургалт явуулна.



БҮРЭЛДЭХҮҮН 2: ТӨСВИЙН ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ

2.1. ТӨСВИЙН ХЯНАЛТАНД УИХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.

- Үр дүнд суурилсан бодлогын шинжилгээ, хяналтыг хэрэгжүүлэх буюу УИХ-ын байнгын хороодтой хамтран салбарын бодлогын хэрэгжилтийн төлөв байдалд үнэлгээ хийнэ.
- Үр дүнд суурилсан төсвийг нягтлан хянах, хяналт шинжилгээг хэрэгжүүлж, УИХ-аас төсөвт ерөнхий хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх арга аргачлалыг сайжруулахад чиглэнэ.
- Бодлого, улсын төсвийн үр дүнтэй уялдааг хангахад УИХ-ын зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Төсөвт хяналт тавих УИХ-ын чадавхыг бэхжүүлнэ.

2.2. ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.

- Салбарын бодлогын шинжилгээ хийнэ.
- Төсвөөс санхүүжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд санхүүгийн болон санхүүгийн бус гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх ИНБ-ын чадавхыг сайжруулна.
- Төсөвт явцын хяналт хийх, хянах чиглэлээр ИНБ, хэвлэл мэдээллийн чадавхыг сайжруулна.

2.3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫГ БЭХЖҮҮЛЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАНА.

- ТХЗ-ын тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдэд гүйцэтгэлийн аудит хийнэ.
- Аудитын 'иргэний танхим' байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх замаар улсын төсөвт хяналт тавихад иргэний идэвхтэй оролцоог нэмэгдүүлнэ.
- Гүйцэтгэлийн аудит хийх УАГ-ын чадавхыг бэхжүүлнэ.

БҮРЭЛДЭХҮҮН 3: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЧАДВАР, БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

3.1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ САЙЖРУУЛЖ, УЯЛДААГ ХАНГАНА.

- Тулгамдсан гол бэрхшээл саадыг тогтоох зорилгоор одоо хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн зураглал, үнэлгээ хийнэ.
- Хөдөлмөрийн зах зээл, орон нутгийн эдийн засгийн бодлогыг харгалзсан, санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгийг хамруулсан, уялдаа холбоо бүхий хөтөлбөр хэрэгжүүлэх дэмжих үйлчилгээг загварчлан бүтээнэ.
- Дэмжих үйлчилгээг үндэсний хөтөлбөр, яамны төсвийн багцад суулган, хариуцах эзэн, санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулна.

3.2. ИННОВАЦ, ГАРААНЫ БИЗНЕС, ТЕХНОЛОГИ, БИЗНЕС ИНКУБАТОР, БИЗНЕС САНААГАА ҮЙЛ ХЭРЭГ БОЛГОХ ЭКОСИСТЕМ ХӨГЖҮҮЛНЭ.

- Шинэлэг болон гарааны бизнесийн санаачилгыг дэмжих нэгдсэн платформ бий болгон, хэрэгцээндээ тохирсон тусгайлсан дэмжлэг авах, мэдлэг мэдээлэл солилцох боломжийг ажил олгогч, ажилтан, ажил хайгчдад олгоно.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөгжлийн түншүүдийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн нэгдсэн зураглал, үнэлгээ хийж, хөдөлмөр эрхлэх чадвар, боломжийг өсгөх алсыг харсан экосистем бүрдүүлнэ.
- Залуучууд, алслагдсан нутгийн ажил хайгч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гарааны бизнесийг дэмжинэ.





3.3. ЦАЛИН ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОН ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЧАДАВХ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.

- Загварлан зохион бүтээх сэтгэлгээ, зан үйлд суурилсан аргачлалын талаар чиглүүлэгчийн чадавх хөгжүүлэх үйлчилгээ, мөн санаагаа үйл хэрэг болгох ур чадварт суурилсан сургалтын аргыг боловсролын байгууллагын бүтцэд оруулж хөгжүүлнэ.
- Мэргэжлийн зөвлөгөө өгөх мастер сургалт явуулах цахим платформыг өргөжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зайнаас хүргэх чадавхыг дээшлүүлэх замаар хүртээмж, хамрах хүрээг өргөжүүлнэ.
- Ажил олгогчдод чиглэсэн арга хэмжээ, ажил олгогч-ажилтны харилцааг дэмжсэн байнгын ажиллагаатай механизм бий болгоно.

3.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХЭД ҮР ДҮНТЭЙ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ НОТОЛГОО, СУРГАМЖ ЦУГЛУУЛАХ, УЛМААР БОДЛОГОД ТУСГАХ ЗОРИЛГООР ТУРШИЛТЫН ТӨСЛҮҮД ХЭРЭГЖҮҮЛНЭ.



- Үндэсний хөтөлбөрүүдийг газар дээр нь уялдаатай хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн салбарт залуучуудыг олноор нь ажиллуулах боломж олгох төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр дүнтэй загварыг илрүүлж, загварлан бүтээж, туршина.
- Монгол Улсын агро-бизнес эрхлэгчид хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд ахин дэвшихийг дэмжсэн бүтэц, зохион байгуулалтын болон техникийн шинэчлэлийг туршин, дэмжинэ.
- Үндэсний болон олон улсын зах зээлд өрсөлдөхүйц, үндэсний болон олон улсын чанар, аюулгүйн стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүний үндэсний брэндүүд бий болгохыг дэмжинэ
- Монгол Улсын агро-бизнес суурилсан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, тулгамдаж буй сорилт бэрхшээлийг тодорхойлон, загварлан бүтээж, туршина.
- Арьс шир, үслэг ба ноосон бүтээгдэхүүн зэрэг хүнсний бус хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг дэмжих загвар сургалтын төв байгуулж, туршина.






БҮРЭЛДЭХҮҮН 4: ХӨДӨЛМӨРИЙН ИНСТИТУТЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ

4.1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦҮҮЛНЭ.

- Хөдөлмөрийн хяналтын тухай ОУХБ-ын 81 дүгээр конвенц(1947), Хөдөлмөрийн хяналтын тухай (хөдөө аж ахуй) ОУХБ-ын 129 дүгээр конвенц(1969)-д нэгдэн орох, ОУХБ-ын суурь конвенц, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой конвенцуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Хөдөлмөрийн хяналтын үр дүнг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль эрх зүйн орчныг сайжруулах, түүний дотор Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг асуудлаар зөвлөмж боловсруулна.
- Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт дэд хорооноос олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, Монгол Улсын хүлээх үүргийн талаар судалж, нийгмийн түншлэл, хэлэлцээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцүүлэх, албан бус эдийн засгийг албажуулах зорилгын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийн явцад гарсан анхаарах шаардлагатай асуудлыг тодорхойлно.
- Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрх, зохистой хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлтийг албажуулах, хамтын хэлэлцээр зэрэг асуудлаар МАОЭНХ болон МҮЭХ үр дүнтэй нөлөөлөл сурталчилгаа хийхэд дэмжлэг үзүүлнэ.
- Мэргэжлийн холбоод, Зохистой хөдөлмөрийн төлөөх залуучуудын үндэсний сүлжээг дэмжих замаар нийт залуучуудад хөдөлмөрлөх эрхийг нь эдлүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг албажуулах зэрэгт чиглэсэн үйл ажиллагааг дэмжинэ.

4.2. ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛНА.

- Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах стратеги төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.
- Хяналт шалгалтын арга хэмжээг баримт нотолгоонд суурилан боловсруулж байхын тулд хяналт шалгалтын мэдээлэл цуглуулалт (нас, хүйсийн задаргаатай), дүн шинжилгээ, тархаалтын байдалд үнэлгээ хийнэ.
- МХЕГ-ын хяналт шалгалтын мэдээллийн системийг сайжруулах, шинэчлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тоо баримт цуглуулж буй өнөөгийн тогтолцоог сайжруулах зөвлөмж боловсруулна.
- Ажлын байран дахь хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөрлөх эрхийн асуудлаар сургалтын хөтөлбөр боловсруулж, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвийн үйл ажиллагаатай уялдуулан, улс, аймаг, сумын түвшний нийгмийн даатгал, хөдөлмөр, эрүүл ахуйн хяналтын албадыг хамруулан хэрэгжүүлнэ.



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБ-ын Байр, Нэгдсэн Үндэстний
гудамж-14, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-14201, Монгол Улс
Утас: 976-11-37585
Факс: 976-11-
326221 registry.mn@undp.org
www.mn.undp.org

